

## ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОХ ТӨСӨЛ ХҮЛЭЭН АВАХ ТУХАЙ

Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан “ Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн төслийг хүлээн авах үйл ажиллагааг 2023 оны 02 дугаар сарын 09-ны өдрөөс орон даяар нэгэн зэрэг авч эхэллээ.

ХХААХҮ-ийн Сайдын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/37 дугаар тушаалаар батлагдсан хөнгөлөлттэй зээл олгох Ерөнхий нөхцөл, салбар, чиглэлийн дагуу төсөл хүлээн авах бөгөөд **Бичил** ангилалд хамаарах жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн ирүүлсэн төслийг Жижиг, дунд үйлдвэрийн газар болон аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газар сонгон шалгаруулна.

### Төсөл хүлээн авах хугацаа:

Эхлэх: 2023 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн өглөөний 08:30 цагаас

Дуусах: 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн өглөөний 08:30 цаг хүртэл  
Төслийн материалыг зөвхөн [www.sme.gov.mn](http://www.sme.gov.mn) цахимаар хүлээн авна.

### Хөнгөлөлттэй зээлийн нөхцөл:

- |   |        |                  |
|---|--------|------------------|
| - Зээлийн зориулалт:                            | Үндсэн | хөрөнгө оруулалт |
| - Зээлийн хугацаа:                              | 5      | хүртэл жил       |
| - Зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа: | 12     | хүртэл сар       |
| - Зээлийн хүү:                                  | 3      | хувь             |

### Зээл олгох салбар:

1. Хүнсний үйлдвэр:

✓ Сүү, сүүн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэр;

✓ Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр;

✓ Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ боловсруулах үйлдвэр;

✓ Хүнсний зориулалтын сав, баглаа боодлын үйлдвэр

2. Газар тариалан:

✓ Хүлэмжийн аж ахуй-Мод, жимс, хүнсний ногооны үр үрсэлгээ/Тэрбум мод хөдөлгөөн/

✓ Хүнсний ногооны зоорь, газар тариалангийн бүтээгдэхүүний агуулах

3. Хөнгөн үйлдвэр:

✓ Оёмол бүтээгдэхүүн үйлдвэр

✓ Арьс ширэн бүтээгдэхүүний үйлдвэр;

✓ Гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэл

4. Мал аж ахуй:

✓ Гахай, шувуу, зөгийн аж ахуй

✓ Эрчимжсэн мал аж ахуй

✓ Мал эмнэлгийн үйлчилгээ

**Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн ангилал, олгох зээлийн хэмжээ**

№	Ангилал*	Ажилчдын тоо	Зээл олгох хэлбэр	Борлуулалтын орлого /төгрөг/	Зээлийн хэмжээ /төгрөг/	
					доод	Дээд
1	Бичил	1-9	Сангаас шууд олгоно	0-100 сая хүртэл	20,000,000	100,000,000
				100-200 сая хүртэл	20,000,000	200,000,000
				200 саяас дээш	20,000,000	300,000,000
2*	Жижиг	10-49	Арилжааны банкаар дамжуулан “JICA-ийн санхүүжилттэй Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчныг хамгаалах-II үе шаттай төсөл”	300.0 сая-1.0 тэрбум төгрөг хүртэл	20,000,000	800,000,000
	Дунд	50-199		1.0-2.5 тэрбум төгрөг хүртэл		

**Тайлбар 1.** Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч та Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуульд заасны дагуу аль ангилалд байгаа талаарх тодорхойлолтоо <https://burtgel.sme.gov.mn/> цахим эсхүл аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газраас авна.

**Тайлбар 2.** Жижиг, дунд ангилалд хамаарах үйлдвэр, үйлчилгээ Арилжааны банкуудаар дамжуулан олгож буй JICA-ийн санхүүжилттэй “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчныг хамгаалах-II үе шаттай төсөл”-ийн жилийн 6%-ийн хүүтэй 10 жилийн хугацаатай төслийн зээлд хамрагдах боломжтой.

**Дэлгэрэнгүй мэдээллийг:**

- [www.sme.gov.mn](http://www.sme.gov.mn) веб хуудас, <https://bulgan.hhaag.gov.mn/> хуудас
- “Жижиг дунд үйлдвэрийн газар / SME Agency of Mongolia” пэйж хуудас,
- “77485555-1” дугаарын утас, Аймгуудын “Хүнс, хөдөө аж ахуйн газар”-ын **70343117, 92033888** утаснаас лавлана уу.
- Арилжааны банкаар дамжуулан олгож буй JICA-ийн санхүүжилттэй “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчныг хамгаалах-II үе шаттай төсөл”-ийн зээлд хамрагдахыг төсөл хүсвэл хүлээн авах хугацаа хамаарахгүй бөгөөд зээл хүсэгч та Хаан, Капитрон, Голомт, Худалдаа хөгжил, Төрийн банкуудад шууд хандана.